



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 1/439

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Манхан сумын нутгаар дайран өнгөрч буй Төгрөг, Цэнхэрийн голоос тэжээгддэг Нарийн гол, Төнхлөгийн ганга усгүй болсны улмаас Цагаан нуур, Сэжүүрийн нуур, Бижгэн нуурууд ширгэсэн гэх нөхцөл байдалд газар дээр нь танилцаж шалтгааныг илрүүлэн дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батбаяр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд:

Б.Батбилэг (Зэрэг сумын Засаг дарга)

Т.Лхагвасүрэн (Манхан сумын Засаг дарга)

Х.Мөнхжаргал (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Э.Оюунтунгалаг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Сүхцэрэн (Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч)

М.Энхтайван (Хар нуур Ховд голын сав газрын захиргааны мэргэжилтэн)

Т.Бямбажаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Нямдаваа (Хар нуур Ховд голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Үүссэн нөхцөл байдалд хууль журмын хүрээнд шуурхай арга хэмжээ авч, үр дүнг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнаж дүгнэлт гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН

84000001 1061
Zah A/439 Ba